



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2017 оны 04 сарын 04 өдөр

Дугаар 108

Улаанбаатар хот

**Хязгаарлагдмал хариуцлагатай компани  
байгуулах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, Компанийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5.2 дахь заалт, Засгийн газрын 2017 оны 92 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Сайдын 2017 оны 60 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Бүгд Найрамдах Энэтхэг Улсын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх "Газрын тос боловсруулах үйлдвэр барих" төслийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах үүрэг бүхий "Монгол-Газрын тос боловсруулах үйлдвэр" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулсугай.

2. "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийг нэгдүгээр, зохион байгуулалтын бүтцийн схемийг хоёрдугаар хавсралт ёсоор баталсугай.

3. "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн орон тооны хязгаарыг 11 байхаар тогтоосугай.

4. "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийг зохих журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлж, үйл ажиллагааг эхлүүлэхийг гүйцэтгэх удирдлагад даалгасугай.

5. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ), Захиргаа, хууль зүйн хэлтэс (Б.Гаваа)-т тус тус даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ З  
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б. ГАВАА